

ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧИГЛЭЛЭЭР
ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН
/2018.10.26-2018.11.27/

1. Томилогдсон, түр томилогдсон албан хаагчийн талаар:

Тайлангийн хугацаанд:

- 1.1 Ажилд томилогдсон: Эрх, зүй гадаад харилцааны хэлтсийн хуулийн ахлах мэргэжилтнээр Г.Ганбатыг томилсон байна.
- 1.2 Шинээр томилогдсон төрийн үйлчилгээний албан хаагч: байхгүй
- 1.3 Дэвшүүлэн томилсон: байхгүй.
- 1.4 Шилжүүлэн томилсон: байхгүй
- 1.5 Түр орлон гүйцэтгүүлэх: байхгүй

2. Чөлөөлөгдсөн, түр чөлөөлөгдсөн, халагдсан албан хаагчийн талаар:

2.1. Төрийн захиргааны албан хаагчид: Баруун бүс дэх газрын мэргэжилтэн В.Энхтайван, Дүн шинжилгээ, дотоод аудитын хэлтсийн аудит хариуцсан ахлах мэргэжилтэн Д.Болор-Эрдэнэ, Тамгын газрын дарга М.Төрбат нарын 3 албан хаагч чөлөөлөгдсөн.

2.2 Түр чөлөөлөгдсөн: Тамгын газрын дарга М.Төрбат

2.3 Төрийн үйлчилгээний албан хаагчид: Хангалт үйлчилгээний газрын жолооч-автомеханикч Б.Хүрэлхуяг,

2.4 Эрх түдгэлзүүлдсэн тухай: Баруун бүс дэх газрын Баян-Өлгий аймаг дахь хэлтсийн хяналтын улсын байцаагч Х.Өмиргүлийн улсын байцаагчийн эрх, хяналтын улсын байцаагч Д.Мырзабекийн мөн улсын байцаагчийн эрхийг тус тус түдгэлзүүлэв.

3. Чөлөө олгосон талаар: Гэр бүлийн гишүүний эрүүл мэндийн байдал, бичгээр гаргасан хүсэлтийн дагуу Б.Одмаад 60 хоногийн чөлөө, Виз, зөвшөөрлийн газрын дарга Ч.Нармандахд 2019 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр хүртэл Пүрэв гараг бүр чургалтын чөлөө, Харьяатын газрын мэргэжилтэн Н.Халиун 12 дугаар сарын 28-ны өдрийг дуустал ажлын өдөр бүр 1 цагийн чөлөө, Буянт-Ухаа дахь газрын хяналтын улсын байцаагч Д.Мөнхчимэгт хүүхэд асрах чөлөө авсан байна.

4. Мөнгөн тусламж, шагнал урамшуулал олгосон талаар:

Тусламж – Ар гэрийн гачигдал гарсан Виз, зөвшөөрлийн газрын мэргэжилтэн Д.Мандахд 240.000 мянган төгрөгийн тусламж, Мэдээллийн технологийн хэлтсийн сүлжээний ерөнхий инженер Ш.Алтантулга, Буянт-Ухаа дахь газрын хяналтын улсын байцаагч Д.Мөнхчимэг, нарын гэр бүлд шинээр хүүхэд төрсний 100,000 төгрөг буюу нийт 2 албан хаагчид 200,000 мянган төгрөгийн тусламж олгосон.

Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолоор баталсан "Төрийн үйлчилгээний албаны албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам"-ын дагуу 11 сард 74 төрийн үйлчилгээний албан хаагчид цалингийн 5%-25% -ийн ур чадварын нэмэгдэл олгосон байна.

5. Сахилгын шийтгэл ногдуулах тухай: Баруун бүс дэх газрын виз, зөвшөөрлийн ахлах мэргэжилтэн Г.Батцэцэгт сануулах, Баруун бүс дэх газрын дарга Г.Эрдэнэзаяа, ахлах нягтлан бодогч Б.Зоригтбаатар, Баян-Өлгий аймаг дахь хэлтсийн дарга Д.Мягмаржав, мөн хэлтсийн хяналтын улсын байцаагч Д.Мырзабек нарт 3 сарын цалинг 20 хувь хасах сахилгын шийтгэл тус тус ногдуулсан.

Үндсэн үйл ажиллагааны чиглэлээр:

Сар бүрийн хариуцсан ажлын хүрээнд албан хаагчдын цагийн тооцоо, ур чадварын нэмэгдлийг тооцож, нэгтгэн батлуулан холбогдох газар хэлтэст хүлээлгэн өгсөн.

Байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-ын нэмэлт өөрчлөлт, “Хилийн боомт, орон нутагт ажилласан 5 жил тутам олгогдох урамшуулалын журам”-д тус тус санал өгсөн.

Төрийн мэргэшсэн албан хаагчийн үйл ажиллагааны шалгалтанд албан хаагч нарын анкет хувийн хэрэг,

2019 оны даргын үр дүнгийн гэрээнд тусгагдах ажлын санал өгсөн.

Сахилга хариуцлагын 2018 оны хуралд хүний нөөцийн чиглэлээр мэдээлэл хийсэн.

ТАЙЛАН БИЧСЭН: ХҮНИЙ НӨӨЦИЙН
МЭРГЭЖИЛТЭН

М.ӨНӨРЦЭЦЭГ

ХЯНАСАН: ХҮНИЙ НӨӨЦИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Д.ШИНЭБАЯР